

## ӨГҮҮЛЭЛ

**Монгол ба Японы хооронд 1972 онд дипломат харилцаа тогтоосон нь: 50 жилийн өндөрлөгөөс нягтлан шинжихүй**

**Цэдэндамбын Батбаяр**

Академич, доктор Sc.D

Шинжлэх Ухааны Академийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн

Улаанбаатар, Монгол Улс

[tsedendamba.bud@gmail.com](mailto:tsedendamba.bud@gmail.com)

**Хураангуй:** БНМАУ болон Япон улсын хооронд 1972 оны 2 дугаар сард албан ёсны дипломат харилцаа тогтоосон явдал нь Өрнөдийн гүрнүүдээс зөвхөн Их Британи, Франц зэрэгтэй дипломат харилцаатай байсан Монгол улсын хувьд гадаад харилцаагаа тэлэх томоохон алхам болсон юм. Монгол-Японы хооронд дипломат харилцаа тогтоох үйл явц ийнхүү 1970-аад оны эхэн хүртэл сунжирсан явдал нь маргаантай хэд хэдэн асуудлаас үүдэлтэй байв. Дайны төлбөрийн асуудал, Японы олзны цэргүүдийн асуудал саад тотгор болж байв. Варшав, Москвагаар дамжин эхэлсэн хоёр талын албаны хүмүүсийн тандалтын шинжтэй яриа хэлэлцээ 10 орчим жил үргэлжилж, 1972 оны 2 дугаар сард Москвад хоёр орны Элчин сайд нар тодорхой шийдэлд хүрснээр төгсгөл болсон билээ. Тэр үеийн дэлхийн улс төрийн харилцаа, нэн ялангуяа Ази, Европын хүйтэн дайн, ЗХУ, БНХАУ, Тайвань, Америк зэрэг ээдрээ төвөгтэй харилцаа нөлөөлж байсан бөгөөд Япон Монголын хооронд тухайлбал, Халх голын дайн, дэлхийн II дайны үеийн 80 сая америк долларт хүрэх хэмжээний дайны нөхөн төлбөрийн асуудал, харилцан ойлголцол хангалтгүй зэрэг шалтгаан байсан юм. Нэмж хэлэхэд БНМАУ-ын гадаад бодлого ЗХУ-ын нэгдсэн бодлогод захирагдаж байсан, Япон ч гэсэн АНУ-ын “атомын шүхэрт” дулдуйдаж, АНУ-ын холбоотон Тайваньтай найрамдлын гэрээтэй, Тайваний арлын эрх баригчдад ховсдуулсан байсныг хэлэх нь зүйтэй.

**Түлхүүр үгс:** Монгол, Япон, ЗХУ, “хүйтэн дайн”, хэвийн харилцаа, дайны төлбөр, сайн санааны айлчлал,



БНМАУ болон Япон улсын хооронд 1972 оны 2 дугаар сард албан ёсны дипломат харилцаа тогтоосон явдал нь Өрнөдийн гүрнүүдээс зөвхөн Их Британи, Франц зэрэг орнуудтай дипломат харилцаатай байсан Монгол улсын хувьд гадаад харилцаагаа тэлэх томоохон алхам болсон юм. Монгол-Японы хооронд дипломат харилцаа тогтоох үйл явц ийнхүү 1970-аад оны эхэн хүртэл сунжирсан явдал нь маргаантай хэд хэдэн асуудлаас үүдэлтэй байв. Эхний асуудал нь дайны төлбөрийн асуудал байв. Энэ асуудал нь бүр 1946 оноос эхлэн тавигдсан бөгөөд хоёр тал тодорхой шийдлийг олтол олон жил болсон юм. Дайны төлбөрийн асуудлаар анх 1946 оны 10 дугаар сард БНМАУ Алс Дорнодын Комисст өргөдөл өгсөн байна. Алс Дорнодын Комисс нь 1945 оны 12 дугаар сард Москвад болсон Их гүрнүүдийн ГЯЯ-ны сайд нарын зөвлөгөөнөөр байгуулагдсан бөгөөд ялагдсан Японы талаарх холбоотон гүрнүүдийн бодлогыг зохицуулах үүрэгтэй комисс байв. Алс Дорнодын комисс нь тухайн үед Японы түрэмгийлэлд нэрвэгдсэн Хятад, Филиппин зэрэг орнуудад Японоор хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг хэлэлцэж байжээ.

Үүнтэй холбогдуулан БНМАУ-ын Ерөнхий сайд бөгөөд ГЯЯ-ны сайд Х.Чойбалсан 1946 оны 10 дугаар сарын 2-нд Алс Дорнодын комиссын дарга ноён Фрэнк Маккойд захидал илгээсэн байна. Уг захидалд “Японы милитаристууд 1935 оноос эхлэн БНМАУ-ын эсрэг зэвсэгт халдлага хийж ирснийг дурдаад 1933-38 онд Монголын арми 233 хүнээ алдаж, 11

сая төгрөгийн хохирол үзсэн, Халхын голын дайнд Монголын арми 1131 цэргээ алдаж, 60 гаруй сая төгрөгийн хохирол үзсэн” гэжээ. Түүнчлэн НҮБ-ын нийтийн хэрэгт хувь нэмрээ оруулах үүднээс 1945 оны 8 дугаар сарын 10-нд Японд дайн зарлаж милитарист Японыг бүрмөсөн бут цохиход оролцсоноо дурдаад энэхүү үйл ажиллагаанд Монголын тал 75 хүнээ алдаж, 249 сая төгрөгийн хохирол үзсэн гэжээ. Ийнхүү БНМАУ-ын нийт хохирол 1935-45 оны хооронд 2039 хүний амь, 321 сая төгрөг болсон гэж танилцуулсан байна. Ингэснээр БНМАУ Японы түрэмгийллээс болж хохирсон эд материалын хохирлыг нөхөн төлүүлэхийн тулд Японоос дайны төлбөр нэхэмжлэх бүрэн эрхтэйгээ Алс Дорнодын комиссын даргад сонордуулсан байна.<sup>1</sup>

Монгол-Японы харилцааг хэвийн болгоход тодорхой хэмжээгээр саад болж байсан өөр нэг асуудал бол 1945-1947 онд Монголд байсан Японы олзны цэргүүдийн тухай асуудал юм. Монгол улсын Гадаад харилцааны төв архивд байгаа материалаас үзвэл БНМАУ-ын СнЗ-ийн дэргэдэх Олзлогдогсдын хэрэг эрхлэх газар нь 1945 оны 11 дүгээр сарын 20-ноос 12 дугаар сарын 20-ны хооронд бүгд 6 удаагийн эшелонор 12318 японы олзлогдсон цэрэг, офицерыг ЗХУ-аас хүлээн авчээ. Тэдгээр олзны япончууд нь Улаанбаатар хот, Төв болон Сүхбаатар аймгуудад голдуу барилгын ажил хийж байсан байна. 1945-47 оны хооронд тэднээс 1613 хүн өвчнөөр, мөн өөр элдэв шалтгаанаар хорогдсон ажээ. Үлдэх 10713 цэрэг, офицерыг 1947 оны 10 дугаар сард Зөвлөлтийн талд

1 Монгол Улсын Гадаад харилцааны төв архив. Х- 59, Д-1, ХН. 34, 1-4-р тал.

хүлээлгэн өгсөн түүхтэй.<sup>2</sup>

1950-иад оны дундуур Европт ч тэр, Азид ч тэр олон улсын харилцаанд намжмал байдал бий болж, энхийн уур амьсгал тогтож эхэлсэн цаг ирэв. Солонгосын дайн 1953 онд дуусгавар болж, Энэтхэг-Хятадын хойгийн асуудлаар Женевийн бага хурал 1954 онд болж Вьетнамд түр ч болов байлдааны ажиллагаа зогсов. Мөн 1954 онд Хятад, Энэтхэгийн хоорондын хэлэлцээрт анх томъёолсон “Панча Шила” буюу нийгмийн өөр өөр байгуулалтай улсууд энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчмыг тунхаглав. 1955 онд Индонезийн Бандунгт хуралдсан Ази, Африкийн 29 орны төлөөлөгчдийн бага хурал дээрх 5 зарчмыг хүлээн зөвшөөрөөд, төгсгөлийн баримт бичигтээ 10 зарчим болгон баяжуулсан нь олон улсын харилцааг шударга үндсэн дээр хөгжүүлэхэд дөхөм үзүүлжээ.<sup>3</sup>

1954 оны 12 дугаар сард байгуулагдсан Хатояма Ичиро тэргүүтэй Японы шинэ Засгийн газар дотооддоо Үндсэн хуулиа шинэчлэх, гадаад талдаа АНУ-тай нягт хамтран ажиллахын зэрэгцээ социалист хүрээллийн орнуудтай харилцаа тогтоон хөгжүүлэх гэсэн шинэлэг байр суурь баримтлав. Энэ бодлогынхоо хүрээнд Хатоямагийн засгийн газар 1955 онд БНХАУ-тай худалдааны хэлэлцээр байгуулж, 1956 оны 10 дугаар сард ЗСБНХУ-тай дипломат харилцаа сэргээн тогтоох тухай “Хамтарсан тунхаглал”-д гарын үсэг зурав. “Япон улс, ЗСБНХУ-ын хамтарсан тунхаглал”-д хоёр тал дайны байдлыг төгсгөх, дипломат

харилцааг сэргээх, НҮБ-ын дүрмийг хүндэтгэн үзэж бие биеийн дотоод хэрэгт хөндлөнгөөс үл оролцох, Япон улс НҮБ-д гишүүнээр элсэн орохыг дэмжих, ЗХУ-д буй Японы олзлогдсон цэргүүдийг эх оронд нь буцаах, сураггүй бологсдыг эрж сурвалжлах, дайны төлбөрийн асуудлыг бие биедээ тавихгүй байх, энх тайван найрамдлын гэрээ байгуулах асуудлыг цаашид үргэлжлүүлэн хэлэлцэх, газар нутгийн асуудлыг зохистой хэлбэрээр шийдвэрлэх зэрэг заалтууд багтжээ. Энэхүү хамтарсан тунхаглал нь Монгол-Японы харилцааг хэвийн болгоход ч нэг ёсны удирдамж, загвар болж өгөх ёстой байв.<sup>4</sup>

Японы “Kyodo News” агентлагийн сурвалжлагч К.Ёриока Монголд очих хүсэлт тавьж зөвшөөрөл авсны үндсэн дээр 1956 оны 4 дүгээр сард Монголд ирж, СнЗ-ийн дарга Ю.Цэдэнбалаас сурвалжилга авсан байна. Түүнчлэн СнЗ-ийн орлогч дарга Л.Цэнд, Ардын Их хурлын дарга Д.Дамба нар түүнийг хүлээн авчээ. Тэд Япон улстай хэвийн харилцаа тогтооход нааштай хандаж байгаагаа илэрхийлж, эрх тэгш, харилцан ашигтай байх зарчимд тулгуурлан худалдаа-эдийн засаг, соёлын харилцаа хөгжүүлэхийн чухлыг дурджээ. Ю.Цэдэнбал: *Япон-Монголын хооронд дипломат харилцаа тогтооход болох л зүйл гэж бид үзэж байдаг. Энэ бол бүх улс түмний хамтран ажиллах явдалд тус нэмрийг оруулах чухал зүйл гэж үзэж байна... Дипломат харилцаа тогтооход манай талаас баяр хүргэхээс өөр юмгүй гэжээ. Ю.Цэдэнбал японы олзны хүмүүсийн талаар хариулахдаа:*

2 Гадаад харилцааны төв архив. Х- 59, Д-1, ХН. 42, 73-77-р тал.

3 Монгол Улсын түүх. Тавдугаар боть, Улаанбаатар, 2003, 272-273-р тал.

4 С.Л.Тихвинский. “Россия и Япония обречены на добрососедство”, М., 1996, с. 108-124.

Монголд байсан Японы цэргийн олзлогдогсдыг 1947 онд цөмийг буцаасан. Цэргийн гэмт хэрэгтэн 4-5 хүн байсныг ч буцаасан. Энд нас барсан хүмүүсийн чандрууг нутагт нь буцааж болох юм. Энэ талаар татгалзах зүйлгүй хэмээн мэдэгдэж байжээ.<sup>5</sup>

1950-иад оны дундуур Монгол-Японы хооронд олон нийт, хүмүүнлэгийн салбарт анхны харилцан айлчлалууд хийгдэж, энх тайван, атом, цөмийн зэвсгийг хураах Японы бага хуралд оролцох зэрэг чиглэлээр хамтын ажиллагаа явагдаж, худалдааны харилцааг хөгжүүлэх тухай анхны яриа хэлэлцээнүүд хийгдэж "таатай уур амьсгал" бүрдэж байв.

Зөвлөлт-Японы харилцаа 1956 онд хэвийн болсон явдал нь Монголын удирдагчдад урам зориг өгч, Японтой харилцаагаа хэвийн болгох талаар зоригтой мэдэгдлүүдийг хийх болсон юм. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн /СнЗ/ дарга Ю.Цэдэнбал 1957 оны 5 дугаар сард Москвад айлчилж, ЗХУ-ын СнЗ-ийн дарга Н.Булганинтай яриа хэлэлцээ хийж хоёр орны хамтарсан мэдэгдэл гаргасан билээ. Тэрхүү хамтарсан мэдэгдэлд: *"БНМАУ-ын Засгийн газар ЗСБНХУ ба Япон улсын хооронд дипломат харилцаа сэргээн тогтоосныг сайшаахын хамт БНМАУ ба Япон улсын хоорондын харилцааг хэвийн болгох асуудлын талаар Япон улсын засгийн газартай хэлэлцээ хийхэд бэлэн байгаагаа"* мэдэгдсэн байна.<sup>6</sup>

1950-иад оны дундуур Япон ч тэр, БНМАУ ч тэр НҮБ-д элсэх өргөдлөө зэрэг хэлэлцүүлэв. 1955 оны 12 дугаар сард өргөдөл өгсөн 18 улсыг зэрэг

элсүүлэх тухай Канад зэрэг 28 орны саналыг НҮБ-ын Ерөнхий Ассамблей дэмжсэн байна. Гэтэл түүний зөвлөмжийг Аюулгүйн Зөвлөлөөр хэлэлцэхэд Чан Кайши-гийн төлөөлөгч БНМАУ-д хориг тавьж, ЗХУ-ын төлөөлөгч Японд зөвлөмж өгөхөөс татгалзсан учир БНМАУ, Японоос бусад 16 улсыг НҮБ-ын гишүүнээр баталжээ. Энэ үйл явдал хоёр улс бие биеэ харилцан сонирхоход түлхэц үзүүлж, ялангуяа японы олон нийт БНМАУ-ын бодит байдлыг анхааран сонирхох болсон байна. 1956 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Япон улс НҮБ-д гишүүнээр элсэн орж, олон улсын тавцан дээр эзлэх байр суурь нь нэмэгдсэн юм.

1960-аад оны эхээр Японы албаны хүмүүс БНМАУ-тай харилцааг хэвийн болгох асуудлаар янз бүрийн шугам, сувгаар ярьж эхэлснийг тэмдэглэх нь зүйтэй. Варшавт суугаа Японы дипломатууд БНМАУ-ын ЭСЯ-ны дипломат ажилтан нартай уулзаж, хоёр орны хооронд албан ёсны харилцаа тогтоох талаар манай байр суурийг тандан лавлаж эхлэв. Японы ЭСЯ-ны хэргийг түр хамаарагч Окада Акира 1961 оны 5 дугаар сард Варшав хотод манай ЭСЯ-ны нэгдүгээр нарийн бичгийн дарга Х.Санжмятавтай хэд хэдэн удаа уулзаж энэ сэдвээр ярилцсан байна. Тэрээр Японы тал Варшавт ЭСЯ-аа нээснээс хойш Варшаваар дамжуулан хэлэлцээ хийж, Румын, Болгар, Унгар улсуудтай дипломат харилцаа тогтоосон. Энэ туршлага дээр үндэслэн манай хоёр орны хооронд харилцаа тогтоох талаар бид хамтран ажиллаж болох юм гэжээ.<sup>7</sup>

5 Гадаад харилцааны төв архив. Х- 59, Д-1,ХН. 43, 10-р тал.

6 "Үнэн" сонин, 1957.05.17.

7 ГХТА, Х- 59, Д-1,ХН. 47, 22-23-р тал.

Варшавт болсон уулзалтаас 2 долоо хоногийн дараа Москвад 6 дугаар сарын 21-нд Японы түр хамаарагч Шигэмицү Акира манай Элчин сайд С.Лувсантай уулзав. Тэрээр хоёр орны харилцааны асуудлыг авч хэлэлцэхээс өмнө анхны алхам болгож Японы Засгийн газрын албан ёсны төлөөлөл болох хоёр дипломат ажилтныг Монгол улсад түр хугацаагаар томилон явуулж, Монгол орны хөгжил байдлыг газар дээр нь сонирхон танилцах, мөн албаны хүмүүстэй уулзуулж БНМАУ-ын засгийн газрын байр суурийг тандан мэдэх саналтай байгаагаа илтгэсэн байна. Хоёр ажилтан нь Голландад суугаа Японы ЭСЯ-ны 3 дугаар нарийн бичгийн дарга, монгол хэл сайн мэдэх Мүтоо Такэши, ЗХУ-д суугаа Японы ЭСЯ-ны 3 дугаар нарийн бичгийн дарга, орос хэл сайн мэдэх Акихо Мицутака нар хэмээн танилцуулжээ.<sup>8</sup>

Монголын Засгийн газар уг саналыг судалж үзээд Москвагаар дамжуулан хариуг өгсөн байна. Элчин сайд С.Лувсан Японы түр хамаарагч Шигэмицүтэй 1961 оны 7 дугаар сарын 21-ний өдөр уулзаж дараах хариуг өгчээ. Лувсан: “Монгол-Японы хооронд дайны байдлыг арилгаж, хэвийн харилцаа тогтоох асуудлаар Японы Засгийн газрын нэрийн өмнөөс хэлэлцээ хийх эрх бүхий төлөөлөгчидтэй ярилцахад манай засгийн газар бэлэн байна. Хэрэв тийм хүсэл танай талд байвал хоёр улсын Элчин сайд нарын түвшинд урьдчилан санал солилцоход болох юм” гэжээ. Шигэмицү мөн уулзалтын үеэр БНМАУ, АНУ-ын хооронд дипломат харилцаа тогтоох асуудлаар явагдаж

байгаа яриа хэлэлцээ ямар байдалтай байгааг лавлан асууж байв.

БНМАУ арван таван жил зүтгэсний үр дүнд 1961 оны 10 дугаар сард Нэгдсэн Үндэстний байгууллагын гишүүнээр элсэв. БНМАУ-ыг элсүүлэхийг зөвлөмж болгосон тогтоолын төслийг ЗХУ, Англи, Франц, Цейлон, Чили, Нэгдсэн Араб, Эквадор, Либери, Турк улс дэмжиж, АНУ түдгэлзсэн бөгөөд Чан Кайшийн төлөөлөгч танхимаас гарч санал хураалтад оролцсонгүй. Манай орноос 5 жилийн өмнө НҮБ-д элссэн Япон Улс манай улсыг НҮБ-д элсэхэд татгалзаагүй, тиймээс тэр үес чухам үнэн хэрэгтэй манай орныг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн гэж үзэх болсон гэдэг. Японы Ерөнхий сайд Икэда парламентын чуулган дээр 1963 оны 1 дүгээр сард мэдэгдэхдээ “Монгол улсыг НҮБ-ын гишүүнээр элсүүлэх тухай 1961 оны 10 дугаар сард Ерөнхий Ассамблейгаар хэлэлцэх үед шууд татгалзаагүй явдал Монгол улсыг үнэн хэрэг дээрээ /де-факто/ албан ёсоор хүлээн зөвшөөрсөн зүйл болно” хэмээн мэдэгдэж байв.<sup>9</sup> БНМАУ НҮБ-д элссэн явдал Японд маш их сонирхол татаж, Японы улс төрчид, сэхээтнүүд, олон нийтийн байгууллагынхны хувьд хоёр талын харилцааг хэвийн болгоход асар их түлхэц болсон нь маргаангүй.

1960-аад оны эхний хагаст олон нийтийн байгууллагын шугамаар солилцоо явагдаж, худалдаа, аялал жуулчлалын хэлхээ холбоо үргэлжилж байв. 1961 онд Токиод нээгдсэн Ази, Африкийн зохиолчдын их хуралд зохиолч, хожим нь СнЗ-ийн орлогч дарга Д.Цэвэгмид, 1967 оны Ази, Номхон далайн эдийн засгийн

8 Мөн тэнд, 35-38-р тал.

9 “Асахи шимбүн”, 1963.01.27.

байгууллагын хуралд ГЯЯ-ны 1 дүгээр орлогч сайд Д.Чимиддорж, 1968 онд болсон НУБ-ын Олон улсын хөдөлмөрийн байгууллагын их хуралд Хөдөлмөр, цалин хөлсний улсын Хорооны дарга М.Лхамсүрэн нарыг илгээж оролцуулж байв. СнЗ-ийн орлогч дарга С.Лувсан 1962 оны 8 дугаар сард Х.Хамазаки тэргүүтэй Японы худалдаа, эдийн засгийн төлөөлөгчид ба олон улсын худалдааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх Японы нийгэмлэгийн Ерөнхий нарийн бичгийн дарга Кимура нарыг хүлээн авч уулзжээ.

1965 оны дундуур БНМАУ-ын удирдлага Японтой харилцаагаа хэвийн болгох талаар идэвхтэй санаачилгатай ажиллахаар шийдвэр гарчээ. 1965 оны 8 дугаар сард Улаанбаатарт болох олон улсын эмэгтэйчүүдийн эрхийн семинарт Японы тал ГЯЯ-наасаа хоёр дипломат ажилтан оролцуулах, тэдэнд семинарын дараа Монгол орны байдалтай танилцах зөвшөөрөл олгохыг хүссэн байна. Тэд нь Японы ГЯЯ-ны түшмэл Сакияма Кисабуро, Бангкок-т суугаа Японы ЭСЯ-ны нарийн бичгийн дарга Ханада Марохито нар байв.

1965 онд дэлхийн хоёрдугаар дайн дууссаны 20 жилийн ой тохиож байсантай холбогдуулан БНМАУ-ын засгийн газар Японтой ёс төдий дайны байдлыг цуцлах санаачилга гаргахаар төлөвлөж байсан нь хоёр орны харилцааг хэвийн болгох үүд хаалгыг нээх ёстой байв. Манай ГЯЯ-наас Москвад суугаа Элчин сайд Н.Лувсанчүлтэмд 1965 оны 7 дугаар сарын 30-нд үүрэг өгч Зөвлөлтийн нөхөдтэй дараах хоёр асуудлаар

зөвлөлдөхийг даалгажээ. Нэгд: Японыг ялсны ойг ЗХУ-д хэрхэн тэмдэглэх, хоёрт: Японтой байгаа ёс төдий дайны байдлыг манай талаас санаачлан дангаар цуцлах нөхцөл бүрдсэн эсэх, юуг анхаарвал зохих гэсэн хоёр асуудлыг тавьжээ. Үүний дагуу Москвад суугаа Элчин зөвлөх Сумьяа ЗХУ-ын ГЯЯ-ны Алс Дорнодын хэлтсийн зөвлөх Н.С.Торбенковтой 8 дугаар сарын 4-нд уулзаж ярилцсан байна. Торбенков: *"Танай улс Японтой дайны байдал зогсоох тухай өөрөө санаачилга гаргаж болох юм. Энэ тухай бид Улаанбаатарт ярилцаж байсан удаа бий. Ер нь Японтой ойртох талаар бодлого тавих нь зүйтэй байх"* гэсэн хариулт өгчээ.<sup>10</sup> Гэсэн ч Монголын тал 1965 онд зориглож ийм санаачилга гаргаагүй юм. ГЯЯ-ны нэгдүгээр орлогч сайд байсан Д.Ёндон *"Харамсалтай нь Японы талаас ямар нэгэн нааштай санал санаачилга гаргах төлөвгүй байсан учир Монголын Засгийн газар уг мэдэгдлээ гаргахыг хойшлуулжээ"* гэж хожим өөрсдийгөө зөвтгөн бичсэн байна.<sup>11</sup>

Японы парламентын гишүүн Хасэгава Такаши /ЛАН-ын гишүүн/, Үкэда Синкичи /ЯСН-ын гишүүн/ нарын тэргүүлсэн Монголд нас барагсдын гэр бүл, төрөл садны 8 орчим хүнийг багтаасан 15 хүнтэй томоохон төлөөлөгчид 1966 оны 8 дугаар сарын сүүлээр хүрэлцэн ирж, СнЗ-ийн орлогч дарга, Ардын Их хурлын орлогч дарга, Монголын УЗН-ийн дарга зэрэг албаны хүмүүстэй уулзаж, булш эргэхээр очих гэсэн газарт нь тэднийг очуулж, найрсаг энэрэнгүй сэтгэлээр хүлээн авчээ.

10 ГХТА, Х- 59, Д-1,ХН. 50, 158-159-р тал.

11 Монгол-Японы харилцаа эрт, эдүгээ, Интерпресс хэвлэл, УБ., 2001. 143-р тал.

Японы парламентын гишүүн Хасэгава, Укэда нар 6 дугаар сарын 27-ны өдөр СнЗ-ийн нэгдүгээр орлогч дарга С.Лувсантай уулзахдаа Японы нийгэмлэгийн дарга Фүжиямагаас СнЗ-ийн дарга Ю. Цэдэнбалд өгүүлсэн захидлыг гардуулж, 1966 оны 7 дугаар сард Монголд үер болсонтой холбогдуулан Японы Засгийн газраас 3000 ам. долларын мөнгөн тусламж үзүүлэх, мөн Улаан загалмай нийгэмлэгийн шугамаар эм тан бэлэглэхээр болсныг мэдэгджээ.<sup>12</sup> Энэ нь дэлхийн 2 дугаар дайнаас хойш хоёр орны харилцаанд гарсан хамгийн том ахиц бөгөөд Монгол нутагт нас барсан япончуудын шарилыг эргэхээр олон жил хүсэлт тавьсан явдалд нааштай хариуг өгснөөр онцлогтой байв.

Японы ГЯЯ энэхүү сайн сэтгэлийн айлчлалыг ашиглаж, хоёр талын харилцааг хэвийн болгох асуудлаар яриа хэлэлцээг эхлүүлэх үүднээс ГЯЯ-ны хоёр дипломат: Зүүн Европын хэлтсийн дэд захирал Акихо Мицутака, мөн монгол хэлтэй Ханада Марохито нарыг илгээсэн байна. Акихо бол 1960-1964 онд Москвад Японы ЭСЯ-нд 2 дугаар нарийн бичгийн даргаар ажиллаж байсан, орос хэлтэй, БНМАУ-ын талаар мэдлэгтэй хүн байлаа. БНМАУ-ын ГЯЯ-ны хэлтсийн дарга П. Цэрэнцоодол тэднийг хүлээн авч 8 дугаар сарын 26-28-нд хоёр талын харилцааг хэвийн болгох асуудлаар хоёр ч удаа албан ёсны уулзалт хийж, үдийн зоог барьсан байна. Эхний уулзалт 8 дугаар сарын 26-ны өдөр болжээ. Японы төлөөлөгч М.Акихо хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоох хамгийн хялбар аргыг, тухайлбал Москвад суугаа Элчин сайд нараар дамжуулан хэлэлцээд ноот

солилцох замаар дипломат харилцаа тогтоосноо зарлах санал тавьжээ. Гэвч яриа хэлэлцээний үеэр хоёр орны хооронд дайны байдал байсан эсэх, үүнтэй холбогдон дайны төлбөрийн асуудал зэрэг нарийн төвөгтэй асуудал сөхөгдөн гарч ирсэн байна.

1969 оны 4, 6, 8 дугаар саруудад Москвад суугаа манай Элчин сайд Н.Лувсанчүлтэм, Японы улсын Элчин сайд Т.Накагава нар хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоох асуудлаар 3 ч удаа уулзаж ярилцаж, хоёр талын байр суурийг ойртуулах оролдлого хийсэн байна. Накагава элчин сайд 4 дүгээр сарын 30-ны өдөр уулзахдаа “Японы Засгийн газар БНМАУ-тай дипломат харилцаа тогтоох хүсэлтэй байна. Тэгэхдээ тус хоёр орны хооронд дайны байдал байгаагүй учир уг асуудлыг хөндөхгүй байх, иймээс дайны төлбөр буюу түүнийг орлож болох аливаа асуудал байж болохгүй гэсэн үндсэн дээр ярилцах нь зүйтэй гэж үзэж байна. Японы талын хүлээн авч болохуйц эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны талаар Монголын талын саналыг сонсоход бэлэн байна” гэжээ. Энэ нь үндсэндээ 1966 онд Акихо Мицутака П.Цэрэнцоодолд тавьж байсан саналтай ижил агуулгатай байв.

Хоёр орны хооронд албан ёсны харилцаа тогтоох үйл явцад хоёр орны олон нийтийн байгууллагууд, энх тайван найрамдлын болон улаан загалмайн нийгэмлэгүүд тодорхой үүрэг гүйцэтгэсэн юм. 1968 оны 2 дугаар сард **Япон-Монголын найрамдлын нийгэмлэг** байгуулах хурал болж, түүнд МЭТНБХ-ны Гүйцэтгэх Хорооны дарга Д. Адилбиш уригдсан байна. Уг

12 Монгол-Японы харилцаа эрт, эдүгээ, Интерпресс хэвлэл. УБ., 2001. 144-р тал.

нийгэмлэгийг бэлтгэх хороонд 100 гаруй хүн, түүн дотор Социалист намын Инамура, Сузуки нарын 30 шахам парламентын гишүүд, Японы 48 мужийн захирагчийн 16 нь, мөн олон нийтийн олон зүтгэлтэн багтаж байв. Япон-Монголын найрамдлын нийгэмлэгийн зорилго нь хоёр орны хооронд дипломат харилцаа тогтооход түлхэц үзүүлэх, худалдааны харилцааг өргөтгөх, соёлын харилцааг хөгжүүлэх зэрэг байв. 1968 онд байгуулагдсан Япон-Монголын найрамдлын нийгэмлэг нь /Нихон-Монгору Шинзэн Кёокай/ нь гол төлөв Японы Социалист намын зүтгэлтнүүдээс бүрдсэн бөгөөд түүнээс 4 жилийн өмнө 1964 онд байгуулагдсан Япон-Монголын нийгэмлэг /Нихон-Монгору Кёокай/ гэдгээс зарим талаар ялгаатай байв. 1964 оны нийгэмлэг нь гол төлөв Либерал Ардчилсан намын /ЛАН/ зүтгэлтнүүдээс бүрдсэн, нийгэмлэгийн даргаар Ёо. Мацузаки, нарийн бичгийн даргаар Касуга Юкио нар ажиллаж байв. Ийнхүү Японд хоёр ч нийгэмлэг ажиллах болов.

Энх тайван, найрамдлын байгууллагуудын Хорооны /ЭТНБХ/ Гүйцэтгэх Хорооны дарга Д.Адилбиш Японд 1968 оны 2 дугаар сарын 13-26 нд зочлох хугацаандаа албаны хүмүүс, Японы ГЯЯ-ны Азийн газрын дарга Огава Хэйширо, ГЯЯ-ны ажилтнууд Сакияма, Икэда нар болон 1966 онд Монголд ирсэн ЛАН-ын парламентын гишүүн Хасэгава Такаши нартай уулзсан байна. Огава Хэйширо дайны төлбөрийн асуудал саад болж байгааг тэмдэглэж, урьдын адил Москвад суугаа Элчин сайд нараар дамжуулан яриа хэлэлцээг үргэлжлүүлэх санал

тавьж байв. ЛАН-ын Хасэгава Такаши Монголын тал 1948 онд дайны төлбөр хэмээн 80 сая ам. доллар Японоос нэхэж байсныг сануулаад дайны төлбөр бус эдийн засгийн тусламж гэсэн хэлбэрээр тусламж үзүүлж болох юм гэсэн санал дэвшүүлж байв. Адилбиш “хэвийн харилцаа тогтоосны дараа Япон Улс эдийн засгийн тусламж үзүүлж болох уу?” гэсэн асуултыг сэргүүлэн тавьж байлаа.<sup>13</sup>

Монголын тал ч Д.Адилбишийн айлчлалын мөрөөр зарим арга хэмжээ авах, Монгол-Японы найрамдлын нийгэмлэгийг манайд мөн байгуулах, Японы эрх баригч ЛАН-ын удирдах хүмүүсийг манай тал хүлээн авахад бэлэн байгааг мэдэгдэх саналыг боловсруулж байв. Ийнхүү 1968 онд **Монгол-Японы найрамдлын нийгэмлэгийг зохион байгуулжээ.** Монгол-Японы найрамдлын нийгэмлэгийг санаачлагчдын нэг нь манай нэрт олон нийтийн зүтгэлтэн, зохиолч Л. Түдэв байв. Тэрбээр “Хорин жилийн тэртээх дайсантайгаа тэврэлдэх санаархал” хэмээх дурсамждаа “Монгол-Японы нийгэмлэг нэлээн дуншиж байж 1968 онд мэндэлсэн” тухай, нийгэмлэгийн даргаар нэрт зохиолч, профессор Дондогийн Цэвэгмид, орлогчоор Зохиолчдын холбооны орлогч дарга Л.Түдэв, нарийн бичгийн даргаар орчуулагч Д.Алмаас нар сонгогдож, санаачлагч гишүүд нь ардын зураач Ү.Ядамсүрэн, Гандан хийдийн хамба лам, номч мэргэн Гомбожав, яруу найрагч Л.Хуушаан, М.Цэдэндорж, хэл шинжлэлийн эрдэмтэн Галсанжав, Л.Маналжав, Г.Жамбалсүрэн, Ц.Хандсүрэн нарын тухайн үеийн

13 ГХТА, Х- 59, Д-1, ХН. 52, 31-41-р тал.



сэхээтний нэрт төлөөлөгчид байсныг өгүүлжээ.<sup>14</sup>

МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны 1969 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар Японы талын саналыг хэлэлцэж, цаашид авах алхмын тухай тогтоол гаргажээ. Элчин сайд Н.Лувсанчүлтэм 1969 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Накагава элчин сайдтай уулзахдаа “Монгол, Японы хооронд дайны байдал байгаагүй гэдэг нь бодит байдалд нийцэхгүй. Дайнаас учирсан хохирлын тухай асуудлыг манай улс Японы талд тавих бүрэн эрхтэй. Гэвч танай Засгийн газрын саналыг харгалзан үзэх үндсэн дээр хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоох асуудлаар хоёр Засгийн газрын эрх бүхий төлөөлөгчид ойрын үед уулзан ярилцаж болох юм гэж манай Засгийн газар үзэж байна” гэсэн хариу өгчээ. Мөн Н.Лувсанчүлтэм дайны төлбөрийг Японы тал эдийн засгийн хамтын ажиллагааны хэлбэрээр өгөх үүрэг хүлээсэн тусгай протоколын төсөл болон харилцаа тогтоосон тухай хэвлэлд гарах товч мэдээний төслийг тус тус Накагавад гардуулсан байна.<sup>15</sup>

1970 оны 8 дугаар сард БНМАУ-ын СнЗ-ийн орлогч дарга Д.Гомбожав тэргүүтэй манай Засгийн газрын төлөөлөгчид Япон улсад зочилж, “Экспо-70” үзэсгэлэнг үзжээ. Манай төлөөлөгчдийг японы тал анх удаа Засгийн газрынхаа зочноор хүлээн авсан бөгөөд бүрэлдэхүүнд нь ГЯЯ-ны нэгдүгээр орлогч сайд Б.Жаргалсайхан, Хөнгөн ба Хүнсний үйлдвэрийн яамны орлогч сайд С.Цэвээн нарын албаны хүмүүс орж байв. Төлөөлөгчдийг Японы ГЯЯ-ны сайд К.Айичи 8 дугаар

сарын 15-нд хүлээн авч уулзжээ. Айичи сайд хоёр орны хооронд зөвхөн Элчин сайд нараа харилцан солилцох асуудал үлдэж байгааг хэлэхийн хамт “БНМАУ, Японы харилцааг хэвийн болгох явдалд зөвхөн дайны төлбөрийн асуудал саад болж байна” гэжээ. Өөрөөр хэлбэл, Японы тал дипломат харилцаа тогтоох асуудлыг “дайны төлбөр” хэмээх асуудалтай холбохгүй байх, түүнээс зайлсхийх хувилбар олох гэсэн хэвээр байв. СнЗ-ийн орлогч дарга Д.Гомбожав дайны төлбөрийн асуудлыг дипломат харилцаа тогтоосны дараа ямар нэгэн зохистой хэлбэрээр шийдэж болно гэсэн саналаа дахин давтсан байна. Д.Гомбожав “дайны төлбөрийн хэмжээг ч эргэн хянаж үзэж болно” гэсэн санааг мөн хэлжээ. Манай төлөөлөгчид ГЯЯ-ны сайд К.Айичи-гаас гадна Японы Ерөнхий сайдын Тамгын газрын орлогч дарга Т.Кимура, парламентын гишүүн Т.Хасэгава, Т.Ямагучи нартай уулзсан нь хоёр талын улс төрийн нөлөө бүхий хүмүүс байр сууриа ойлголцоход тодорхой нэмэр болжээ.

Д.Гомбожав нарын төлөөлөгчдийн айлчлалын дүнг МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчоо 1970 оны 9 дүгээр сарын 30-нд хэлэлцэж, чухал тогтоол гаргажээ. Уг тогтоолд:

- Япон Улстай ёс төдий байгаа дайны байдлыг цуцлан зогсоох асуудлыг ойрын хугацаанд боловсруулж Ардын Их Хурлын Тэргүүлэгчдэд оруулах,
- Япон Улстай харилцаа тогтооход дайны төлбөрийн асуудлыг тэр хэвээр дахин тавихгүй, эдийн засгийн хамтын ажиллагааны ашигтай хэлбэрээр зохицуулах санал

14 Ц.Батбаяр. Монгол ба Япон XX зуунд. УБ., 2012, 150-151-р тал.  
15 ГХТА, Х- 59, Д-1, ХН. 63, 53-66-р тал.

тавих,

- Япон Улстай хийж буй худалдааны хэмжээг нэмэгдүүлэх зэрэг бусад тоймтой зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.<sup>16</sup>

Монгол Ардын хувьсгалын 50 жилийн ойд оролцохоор ирсэн Япон-Монголын нийгэмлэгийн дарга Мацузаки Ёо, нарийн бичгийн дарга Касуга Юкио нар 1971 оны 7 дугаар сарын 9-ний өдөр ГЯЯ-ны 2 дугаар хэлтсийн дарга П.Цэрэнцоодолтой уулзаж хоёр орны харилцааг хэвийн болгоход нөлөөлж буй нааштай болон сөрөг хүчин зүйлсийн талаар илэн далангүй ярьсан байна. Ноён Мацузаки Монголд ирэхийн өмнө Японы ГЯЯ-ны сайд К.Айичитай уулзахад тэрээр “Япон улс БНМАУ-ыг хүлээн зөвшөөрсөн гэж үзэж болно. Одоо зөвхөн Элчин сайдаа солилцох л үлдээд байна. Энэ асуудлыг аль болох түргэн шийдэх нь зүйтэй юм” гэжээ.

ГЯЯ-ны 2 дугаар хэлтсийн дарга П.Цэрэнцоодол Мацузаки нартай мөн нэлээд илэн далангүй ярьжээ. Тэрээр “бид ойрын жилүүдэд харилцааг хэвийн болгох талаар голдуу Элчин сайд нарын түвшинд ярилцлаа. Японы тал дайны төлбөрийг төлөхөөс зайлсхийж ирлээ. Бид энэ талаар жич авч үзье, хэмжээг ч дахин хянаж үзэж болно гэсэн. Гэтэл японы тал хүлээж аваагүй. Японы тал дайны төлбөр төлөхгүй гэдэг нэрийдлээр дипломат харилцаа тогтоох явдлыг хойш татаж байна гэж бид үзэж байна. 1970 онд “ЭКСПО” үзэсгэлэнд манай Засгийн газрын төлөөлөгчдийг урьж оролцуулсан. Японы Засгийн газрын сайн санааны төлөөлөгчид энэ онд

айлчлах байх. “Хэрвээ Японы тал сонирхох аваас эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудлаар ярилцаж болох юм гэж бид Японы Засгийн газарт санал тавьсан. БНМАУ бол байгалийн баялаг ихтэй, түүнийг хамтарч ашиглах талаар ярилцаж ч болох юм” гэж ярьсан байна.<sup>17</sup> Монголын байгалийн баялгийг Японтой хамтран ашиглаж болох юм гэсэн зоригтой санааг анх 1971 онд дэвшүүлж байжээ.

1971 оны 9 дүгээр сарын 10-15-ны өдрүүдэд айлчилсан Японы сайн санааны төлөөлөгчдийг СнЗ-ийн орлогч дарга С.Лувсан, ГЯЯ-ны сайд Л.Ринчин нар хүлээн авч уулзан, дайны төлбөрийн асуудлаар байр сууриа тодорхой тайлбарлан ойлгуулахыг хичээснээс гадна төлөөлөгчид Улаанбаатар, Дархан хотод зочилж манай орны бодит байдалтай танилцжээ. ГЯЯ-ны сайд Л.Ринчин *“Бидний бодож байгаагаар хоёр орны хооронд хэвийн харилцаа, дипломат харилцаа тогтооход дайны төлбөрийн асуудал саад болох ёсгүй гэж үзэж байна. Энэ нь хоёр өөр асуудал юм. Дайны төлбөрийн асуудлыг бид болж өнгөрсөн зүйлийг зөв зохицуулан шийдвэрлэх асуудал гэж үзэж байна. Дипломат харилцаа тогтоох нь хоёр орны харилцааг цаашид хэвийн болгож өргөтгөх асуудал гэж үзэж байна. Иймээс дайны төлбөрийн тухай асуудлыг хоёр орны харилцаанд ямар нэгэн болзол болгон ярих нь хэрэггүй юм шиг бидэнд бодогдоно. Хэрэв манай хоёр орны хооронд хэвийн харилцаа тогтоож дипломат харилцаатай болбол тэрхүү дайны өр төлбөрийн тухай асуудлыг зохих хэлбэрээр хоёр*

<sup>16</sup> Монгол-Японы харилцаа эрт, эдүгээ, Интерпресс хэвлэл. УБ., 2001. 151-152-р тал.

<sup>17</sup> Мөн тэнд.

тал тохиролцож болох юм” хэмээн тайлбарласан байна.<sup>18</sup>

Ийнхүү 1970, 1971 онд хоёр улсын Засгийн газрын төлөөлөгчид харилцан айлчилсан нь хараахан дипломат харилцаа тогтоож амжаагүй хоёр орны харилцааны түүхэнд содон үйл явдал болсныг дипломатчид тэмдэглэж байв. Накашима нарын төлөөлөгчдийн айлчлалын тухай товч мэдээ Үнэн сонины 1971 оны 9 дүгээр сарын 11-15-ны өдрийн дугааруудад нийтлэгдэж байв.

Японы ГЯЯ-ны урилгаар манай ГЯЯ-ны 2 дугаар хэлтсийн дарга П. Цэрэнцоодол, ГЯЯ-ны ажилтан Ц.Галсанжав нар 1971 оны 11 дүгээр сарын 5-13-ны өдрүүдэд Япон улсад зочилж, тус орны хөгжил байдалтай танилцахын хамт ГЯЯ-ны орлогч сайд С.Хоогэн, Азийн газрын дарга Р.Сунобэ болон Парламентын нөлөө бүхий гишүүдтэй уулзсан нь нэгэнт бүрдээд байсан хэвийн харилцаа тогтоох явдлыг түргэтгэхэд хүчтэй түлхэц болж өгчээ.<sup>19</sup>

Монголын тал Япон Улстай дипломат харилцаа тогтоох замыг саад бэрхшээлгүй болгох үүднээс Японтой ёс төдий байгаа дайны байдлыг цуцлан зогсоох санаачилга гаргаж, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1972 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн зарлигаар Япон Улстай дайны байдлыг зогсоох шийд гаргав. 1965 оноос хойш дангаар зориглож хийж чадахгүй байсан алхмаа ийнхүү Улаанбаатар хийжээ.

1972 оны 2 дугаар сарын 18-ны өдөр болсон 3 дахь удаагийн уулзалтаар харилцаа тогтоох тухай

хамтран гаргах мэдээний төслийг манай Засгийн газар бүрэн зөвшөөрч байна гэж элчин сайд Нийсэки Кинья мэдэгдсэнээр Монгол, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтоох асуудлаар 1966 оноос хойш үргэлжилсэн яриа хэлэлцээнд төгсгөлийн цэг тавигдсан байна. Элчин сайд нар хамтарсан мэдээг нийтлэх өдөр цаг, бусад техникийн асуудлыг тохиролцох л үлджээ. Ингээд хоёр тал БНМАУ, Японы хооронд дипломат харилцаа тогтоосон тухай албан мэдээг 2 дугаар сарын 19-нд Москвагийн цагаар өглөө 9 цагт нэгэн зэрэг албан ёсоор зарлан, хэвлэлд нийтлэхээр тогтжээ.

“Үнэн” сонинд нийтлэгдсэн “БНМАУ, Япон Улсын хооронд дипломат харилцаа тогтоосон тухай хамтарсан албан мэдээ”-нд “*БНМАУ, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтоож, Элчин сайдын хэмжээнд дипломат төлөөлөгчид солилцохоор БНМАУ-ын Засгийн газар, Япон улсын Засгийн газар шийдвэрлэв. БНМАУ, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтоосон нь хоёр орны эдийн засаг, соёлын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлнэ гэдэгт итгэж байгаагаа хоёр тал илэрхийлэв*” гэжээ.<sup>20</sup>

Эцэст нь Японы эрдэмтэн Койбучи Шиничи 1972 онд дипломат харилцаа тогтоосон явдлыг ингэж авч үзжээ. “Япон-Монголын хооронд чамгүй урт хугацааны турш яагаад дипломат харилцаа тогтоогоогүй юм бол? Монголын талаас 1957 оны үеэс Японтой дипломат харилцаа тогтооё гэж хэд хэдэн удаа хандаж иржээ. Нэг

18 Б.Сэржав. Монгол-Японы харилцаа XX зууны сүүлийн хагаст. УБ., 2003, 39-40-р тал.

19 ГХТА, Х- 59, Д-1, ХН. 61, 19-25-р тал.

20 “Үнэн”, 1972.02.19.

талаар Япон Улс Нэгдсэн Үндэстний байгууллагын гишүүнчлэлийг төв чиг баримжаа болгон үзэх үзлийг гадаад харилцааны үндсэн бодлогоо болгон барьж ирсэн. Тийм атлаа яагаад Монголыг НҮБ-д гишүүнээр элссэнээс хойш 10 гаруй жилийн урт удаан хугацааны турш дипломат харилцаа тогтоогоогүй юм бэ? гэсэн асуулт тавьжээ.

Койбучи Шиничи: “Энэ шалтгаан тэр үеийн улс төрийн харилцаа, нэн ялангуяа Зүүн Европын хүйтэн дайн, Хятад, Зөвлөлт Холбоот Улсын сөргөлдөөн, эс бөгөөс ЗХУ, БНХАУ, Тайвань, Америк зэрэг ээдрээ төвөгтэй харилцаа нөлөөлж байсан бөгөөд Япон Монголын хооронд тухайлбал, Халх голын дайн, дэлхийн II дайны үеийн

80 сая америк долларт хүрэх хэмжээний дайны нөхөн төлбөрийн асуудал, харилцан ойлголцол хангалтгүй зэрэг шалтгаан хөндөлсөж байсан юм. Оюуны түлхүүрээр оролдон тайлах лугаа адилаар эдгээр асуудлыг нэг нэгээр шийдвэрлэж байж л дипломат харилцаа тогтоосон ийм учиртай” гэж үзжээ.<sup>2121</sup> Койбучи эрдэмтэнтэй санал нэг байна. Нэмж хэлэхэд БНМАУ-ын гадаад бодлого ЗХУ-ын нэгдсэн бодлогод захирагдаж байсан, Япон ч гэсэн АНУ-ын “атомын шүхэрт” дулдуйдаж, АНУ-ын холбоотон Тайваньтай найрамдлын гэрээтэй, Тайваний арлын эрх баригчдад ховсдуулсан байсныг хэлэх нь зүйтэй.

---

21 Койбучи Шиничи. Япон-Монгол дипломат харилцаа тогтоосон үеийн тухай дурсамж. [www.jargalsaikhan.coo.mn](http://www.jargalsaikhan.coo.mn) (2021 оны 9 сарын 23-нд хандав)

## Ном зүй:

### Нэг. Архивын эх сурвалж

1. Монгол Улсын Гадаад харилцааны төв архив /ГХТА/.
2. ГХТА, Хөмрөг- 59, Данс-1, ХН. 34, 1-4-р тал.
3. ГХТА, Х- 59, Д-1, ХН. 42, 73-77-р тал.
4. ГХТА, Х- 59, Д-1, ХН. 47, 22-23-р тал, 35-38-р тал
5. ГХТА, Х- 59, Д-1, ХН. 50, 158-159-р тал.
6. ГХТА, Х- 59, Д-1, ХН. 61, 19-25-р тал.

### Хоёр. Цахим баримтууд

1. Койбучи Шиничи. Япон-Монгол дипломат харилцаа тогтоосон үеийн тухай дурсамж. [www.jargalsaikhan.coo.mn](http://www.jargalsaikhan.coo.mn) (2021 оны 9 сарын 23-нд хандав)

### Гурав. Судалгааны зохиолууд

1. Ц.Батбаяр. Монгол ба Япон XX зуунд. УБ., 2012.
2. Монгол Улсын түүх. Тавдугаар боть, Улаанбаатар, 2003.
3. Монгол-Японы харилцаа эрт, эдүгээ, Интерпресс хэвлэл, УБ., 2001.
4. Б. Сэржав. Монгол-Японы харилцаа XX зууны сүүлийн хагаст. УБ., 2003.
5. С.Л.Тихвинский. “Россия и Япония обречены на добрососедство”, М., 1996.

### Дөрөв. Тогтмол хэвлэл

1. “Үнэн” сонин, 1957.05.17.
2. “Асахи шимбүн”, 1963.01.27.

## The establishment of diplomatic relations between Mongolia and Japan in 1972: Looking back at fiftieth anniversary

**Batbayar Tsedendamba**

*Academician, Sc.D*

*Institute of History and Ethnology, Mongolian Academy of Sciences,*

*Ulaanbaatar, Mongolia*

*tsedendamba.bud@gmail.com*

**Abstract:** *The article explores the aspects of the interaction between Mongolia and Japan on the normalization of their bilateral relations starting from 1946 up until 1972. The author divided the process of normalization during that period into three periods: the first period from 1946 to 1960 as initial one, the second period of 1960-1969 during the active engagement, the third one from 1969 to 1972 as the concluding one. The author shows how the war reparation issue created by the Mongolian People's Republic with the backing of Moscow influenced the settlement of disputed issues and interfered into the normalization Mongolian-Japanese relations for many years. The normalization of relations with Japan, a rising power in Asia, for Mongolia was the issue of national accomplishment as a sovereign nation, legitimate right in world affairs and international prestige. The character of the cold war atmosphere between Moscow and Tokyo, between Ulaanbaatar and Tokyo did play a key role in solving difficult and sensitive bilateral issues and the desire of the Mongolian People's Republic to enter official relations with Tokyo was finally realized due to "Nixon shock" and other favorable international circumstances.*

**Keywords:** *Mongolia, Japan, the USSR, Cold War, normalization of bilateral relations, war reparation, goodwill visit*

<i>The day of submission:</i>	2022.08.25
<i>Completion of review:</i>	2022.09.01
<i>Final decision for acceptance:</i>	2022.09.08